

# Тони Квок:



Бараг л өдөр болгон шахуу сонин хэвлэлээс авлигын хэргээр баригдаж шийтгэгдсэн хүмүүсийн мэдээллийг иргэд авдаг байлаа. Ингэснээрээ олон нийтийн итгэлийг улам батжуулж, үүний үр дүнд энэ байгууллагад ирэх гомдол, мэдээлэл ч ихэссэн. Эхний жилдээ 100 гаруй цагдаагийн ажилтан, 100 гаруй төрийн албан хаагчдыг ялласан байдаг юм. Хонконгийн шүүх энэ тал дээр маш сайн ажилласан. Авлигын хэрэгт холбогдсон бүх хүнийг хорих ялаар шийтгэсэн нь авлигыг таслан зогсоох, авлига авч, өгч зүрхлэхгүй байхад бодитой хувь нэмэр болсон юм. Ер нь иймэрхүү замаар үр дүнд хүрсэн дээ.

**-Хувийн хэвшлийнхэн ч танай байгууллагын гадны үлдээгүй биз дээ?**

-Дараа нь бид хувийн хэвшил дэх авлигад анхаарлаа хандуулж энэ талаар үйл ажиллагаа явуулж эхэлсэн дээ. Үүний ачаар хөрөнгө оруулагчдыг татаж, тэдэнд таатай орны нэг болгосон. Гадны хөрөнгө оруулагчид Хонконгт хөрөнгө оруулбал ямар нэг байдлаар хохирохгүй, бүх бизнес эрхлэгчдэд ижил боломж олгодог улс гэдгийг мэддэг, мэдэрдэг болсон.

**-Хэдэн жилийн дараа үр дүнд хүрсэн бэ. Их олон жилийг зарцуулсан уу?**

-Олон хүмүүс авлигатай

гэсэн. Хөрөнгө мөнгөний боломжоосоо шалтгаалаад төвд дөрөвхөн хүн ажиллуулах юм билээ. Ерөнхийдөө ээлжээр ажиллана гэж үзвэл нэг хүн л өдөрт ажиллана гэсэн үг. Хоёр хүн гаднаас зэрэг залгавал хариу өгөх боломжгүй. Залгахад нь утас байнга л завгүй байвал олон нийтийг сэтгэл хангалуун биш байхад хүргэх магадлалтай шүү. Харин манай ийм төвд хориод хүн ажилладаг. Хангалттай төсөвтэй, орон тоотой байж амжилтад хүрнэ. Нийгмээрээ энэ байгууллагыг дэмжиж байж үр дүнд хүрнэ гэдгийг олон улсын туршлага харуулсан шүү дээ.

**-Авлигатай хийх тэмцэл амжилтад хүрч чадах эсэхийг тодорхойлдог гол хүчин зүйл нь юу вэ. Саяхан зохион байгуулсан үндэсний бага хуралд манай УИХ-ын гишүүд, сайд нарын ихэнх нь оролцсонгүй шүү дээ?**

-Үүнийг тодорхойлох гол хүчин зүйл нь дээд шатанд улстөрийн хүсэл эрмэлзэл байна уу, үгүй юу гэдэг асуудал. Засгийн газар авлигатай тэмцэх газарт хэчнээн хэмжээний хөрөнгө хуваарилсан бэ гэдгээр нь юуны өмнө хэмжинэ. Хонконгт Засгийн газрын төсвийн 0.3-0.4 хувийг АЭБДХ-нд зарцуулдаг бол танайд энэ хэмжээ 0.01 хувьд хүрэхтэй үгүйтэй байна. Мөн АТГ-т авлигын асуудлыг мөрдөн

← 1-р нүүрт

Оршуулгын газарт газар авахад хүртэл авлига төлдөг байлаа. Багадаа тохиолдсон нэгэн явдал санаанд орж байна. Манайх гэртээ утас тавиулахаар өргөдөл өгөөд гурван жил болсон. Хариу байдаггүй ээ. Гурван жил хүлээсний эцэст өргөдөл маань шийдэгдэж, инженер, операторууд ирж утас суурилуулах юм болов оо. Тэр үед ах, эгч, дүү бид хэдүүл л гэртээ байв. Утас суурилуулж өгсөн хүмүүс "за одоо утсаа шалга даа" гэхэд нь шалгатал утас ажиллаж байна. "Одоо та нар юу хийхээ мэдэж байгаа биз дээ" гэж тэдний хэлсэн үгний цаад утгыг тухайн үед бидний хэн нь ч ойлгосонгүй. Уг нь тэд утас суурилуулж өгсний хөлс, гар хүндрүүлэх

# Аяга ус уухын тулд ЭМНЭЛГИЙНХЭНД МӨНГӨ ТӨЛДӨГ БАЙЛАА

байгууллага авлигын хэргийг мөрдөн шалгах ямар ч чадамжгүй, өөрсдөө авлигад идэгдсэн юм байна, гуравдугаарт, авлигатай

тэмцэхэд урт хугацаа хэрэгтэй гэж боддог. Хонконгт бол гурван жилийн дараа л гэхэд үр дүн нь мэдрэгдэж байдал шал өөр болсон.

шалгахад хууль эрх зүйн орчин хангалттай байх ёстой. Миний ойлгож байгаагаар Эрүүгийн хууль, ЭБШТХ-д оруулах нэмэлт өөрчлөлтийг